



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 260.

Улаанбаатар хот

Г “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат  
компанийн 2020 оны үйл ажиллагаа, эдийн  
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон  
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх  
хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн  
өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт  
байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн  
ТОГТООХ нь:

1.“Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны эдийн  
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон гүйцэтгэх захирал  
Б.Галбадрахтай байгуулсан контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал  
Б.Галбадрахтай байгуулах контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн  
өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу  
1 жилийн хугацаатай шинэчлэн байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах  
зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж  
болгосугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн  
удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001213

ТӨБЗГ тогтоол-/2021